

# “АРИГ БАНК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

## П.МӨНХ-ЭРДЭНИЙН 2022 ОНЫ 01 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

2022 оны 04 дүгээр  
сарын 05-ны өдөр

Улаанбаатар  
хот

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021.04.05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2022 оны 01 дүгээр улирлын ажлын тайланг хүргүүлж байна. Тайлант хугацаанд Ариг банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал, хойшлогдсон хурал 4 удаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 7 удаа хуульд заасны дагуу танхим, цахим хэлбэрээр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Үүнээс:

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус болон хойшлогдсон хурлууд:

“Ариг банк” ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.9-д “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдана” гэж заасны дагуу тайлант хугацаанд хуралдсан хувьцаа эзэмшигчдийн 4 хурлыг даргалан ажилласан.

- 2022.01.14-ний өдөр хуралдсан ХЭЭБХ – хурлын даргаар томилогдсон, хувьцаа эзэмшигч “Дэм санхүүгийн нэгдэл” ХХК-ийн төлөөлөл хуралд ирээгүй, хуралд хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-ийг төлөөлж хувьцаа эзэмшигч Ш.Баярсайхан, Монголбанкны хянагч Б.Оргилсайхан нар ирсэн. Хурал хууль болон дүрэмд заасан ирц бүрдээгүй учир хуралдаагүй, ТУЗ-өөс хойшлогдсон хурлыг зарлан хуралдуулсан.
- 2022.01.26-ны өдөр хуралдсан ХЭЭБХ /хойшлогдсон/ - хурлын даргаар томилогдсон, хуралд хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал И.Галбуян, Монголбанкны хянагч Б.Оргилсайхан нар ирсэн. Хурлаар 2 асуудал хэлэлцүүлсэн:
  - "Дэм санхүүгийн нэгдэл" ХХК-ийн татгалзсан хувьцааг нөгөө хувьцаа эзэмшигчид санал болгох асуудлыг шийдвэрлэх
  - "Ариг банк" ХХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах  
Эхний асуудал: хувьцаа эзэмшигч "Дэм санхүүгийн нэгдэл" ХХК хувьцаа худалдан авах талаар саналаа ирүүлээгүй тул татгалзсанд тооцсон, энэ хувьцааг нөгөө хувьцаа эзэмшигч "Улаанбаатар импэкс" ХХК-д санал болгох асуудлыг хэлэлцэн Х/22/01 дугаартай "Хувьцаа худалдан авахыг санал болгох тухай" тогтоолыг гаргасан.  
Монголбанкнаас "дүрмийн санг нэмэгдүүлэх зөвшөөрөл"-ийн бичиг ирээгүй тул 2-р асуудлыг хэлэлцүүлээгүй.
- 2022.02.10-ны өдөр хуралдсан ХЭЭБХ – хурлыг даргалсан, хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал И.Галбуян, Монголбанкны хянагч Б.Оргилсайхан, С.Мөнх-Эрдэнэ нар ирсэн. Хувьцаа эзэмшигч "Дэм санхүүгийн нэгдэл" ХХК-ийн төлөөлөл хуралд ирээгүй, хурал хууль болон дүрэмд заасан ирц бүрдээгүй учир хуралдаагүй, хурлаас тогтоол шийдвэр гаргаагүй.
- 2022.03.10-ны өдөр хуралдахаар товлогдсон ХЭЭБХ /хойшлогдсон/ - хурлыг даргалсан, хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал И.Галбуян, Монголбанкны хянагч Б.Оргилсайхан нар ирсэн. Хурлаар 2 асуудал хэлэлцүүлсэн:
  - "Ариг банк" ХХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах,
  - ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалинг нөхөн олгох, ТУЗ гишүүдийн үндсэн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох  
Монголбанкнаас зөвшөөрөл ирээгүй учир тодорхойгүй хугацаагаар хурлыг нээлттэй орхиж, 2022.03.18-ны өдрийн 11 цагаас үргэлжлүүлэн хуралдсан. Хуралд хувьцаа эзэмшигч Улаанбаатар

импэкс ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал И.Галбуян, Монголбанкны хянагч Б.Оргилсайхан нар ирсэн.

Хэлэлцэх асуудал 1: Монголбанкны ерөнхийлөгчийн 2022.03.17-ны өдрийн Н/32 тоот албан бичигт "Ариг банк" ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 14,414,431,377.90 гэсэн дүнгээр нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн учир банкны дүрмийн өөрчлөлтийг хэлэлцэн Х/22/02 дугаартай тогтоолыг батласан.

Хэлэлцэх асуудал 2: ТУЗ-ийн дэргэдэх ЦУНДХ-ы даргаас бэлтгэн ирүүлсэн санал /2018 онд ХЭЭХ-ын тогтоолоор батлагдсан үндсэн цалингийн хэмжээ хэвээрээ, хуралд оролцсоны урамшуулал олгох, үүнийг үндсэн цалингийн 10%-аар тооцон сар бүр нэмж олгох гэсэн санал/-ыг хэлэлцэн Х/22/03 дугаартай тогтоолыг батласан.

### **Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлууд:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 1 дүгээр сард 2, 2 дугаар сард 1, 3 дугаар сард 4 удаа нийт 7 удаа хуралдсан.

2022 оны 1 дүгээр сард оролцсон ТУЗ хурлууд:

1. 2022.01.14-ны өдөр 18 цагаас цахимаар хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хойшлогдсон хурлын товыг зарлах асуудлыг хэлэлцэн, хойшлогдсон хурлыг 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цагт танхимаар хуралдаж хурлаас Т/22/01 дугаартай "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хойшлуулан товлох тухай" тогтоолоор хойшлогдсон хурлыг 2022.01.26 өдөр хуралдуулахаар товлосон.
2. 2022.01.27-ны өдөр 16 цагаас цахимаар хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын товыг зарлах, ТУЗ НБД-ыг томилох асуудлыг хэлэлцэн, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 10:00 цагт танхимаар хуралдахаар товлож Т/22/02 дугаартай "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлах тухай", Т/22/03 дугаартай "ТУЗ-ийн гишүүдийн цалингийн судалгаа хийж танилцуулах тухай" тогтоолуудыг батласан. ТУЗ НБД томилох асуудлыг хойшлуулсан.
3. 2022.02.28-ны өдөр 10 цагаас танхимаар хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлаар дараах асуудлыг хэлэлцсэн.
  1. ХЭЭБХ-ыг хойшлуулан зарлах хугацааг товлох /хурлыг 2022.03.10 өдрийн 10 цагт хуралдуулах Т/22/04 тоот тогтоол батласан/
  2. Дэм санхүүгийн нэгдэл ХХК-ийн татгалзсан хувьцааг нөгөө хувьцаа эзэмшигчид санал болгох / Т/22/05 дугаартай "Хувьцаа худалдан авах тухай санал ирүүлсэнд тооцож, гэрээнд гарын үсэг зурах эрх олгох тухай тогтоолыг гаргасан/
  3. Сонирхоын зөрчилтэй хэлцэл хийх эрх олгох /хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-ийн хамааралтай компани болох "Голден пропертиз" ХХК /С1/ үл хөдлөх хөрөнгө зуучийн компанитай хамтран ажиллах гэрээ хийх зөвшөөрөл олгох СЗХ-ийг хуульд заасан шаардлагыг хангасан шаардлагуудыг тэмдэглэлээр зөвлөн эрх олгосон Т/22/06 тоот тогтоолыг ТУЗ-ийн ХБ 2 гишүүн батласан/
4. 2022.03.11-ний өдөр 10 цагаас цахимаар хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлаар КТХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.4-д заасны дагуу Ариг банк ХХК-ийн ХЭ-ийн ээлжит хурлыг зарлах, хэлэлцэх асуудлыг батлах асуудлыг хэлэлцэн Т/22/09 дугаартай тогтоол гаргасан. "Ариг банк" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10:00 цагт танхимаар хуралдуулахаар шийдвэрлэж, хурлаар дараах асуудлыг танилцуулах, хэлэлцүүлэхээр тогтоосон. Үүнд:
  1. Банкны 2021 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах,
  2. Ногдол ашиг тараах эсэх ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах,
  3. Банкны 2021 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг батлах,
  4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төсвийг батлах,

5. 2022.03.16-ны өдөр 14 цагаас танхимаар хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн батласан.
1. Банкны 2021 оны санхүүгийн болон ҮА-ы тайланг хэлэлцэх / Т/22/08 тоот тогтоол/
  2. Хөндлөнгийн аудитын байгууллагын хийсэн аудитын дүгнэлттэй танилцах,
  3. Банкны 2022 оны санхүүгийн төсвийг хэлэлцүүлэн батлуулах / Т/22/10 тоот тогтоол /
  4. Банкны хэлбэр өөрчлөх төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар танилцуулга
  5. Ногдол ашиг тараах эсэх асуудлыг хэлэлцэх /Т/22/09 тоот тогтоол/
6. 2022.03.29-ний өдөр 14 цагаас танхимаар хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн батласан.
1. "Ариг банкны тогтворжуулах төлөвлөгөө"-г хэлэлцэх /Төлөвлөгөөг Монголбанкнаас гаргасан журамд нийцүүлэн нэмэн сайжруулалт хийлгэхээр зөвлөгөө өгч, сайжруулсан хувилбарыг эхлээд эрсдэлийн хороогоор хэлэлцүүлэхээр хойшлуулав/
  2. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ариунжаргалын хүсэлтийг хэлэлцэх/хойшлуулах/
  3. "Номин даатгал" ХХК-тай хийх сонирхлын зөрчилтэй хэлцэл / хувьцаа эзэмшигч Улаанбаатар импэкс ХХК-ийн хамааралтай компани болох "Номин даатгал" ХХК-тай хамтран ажиллах гэрээ хийх зөвшөөрөл олгох СЗХ-ийг хуульд заасан шаардлагыг хангасан шаардлагуудыг тэмдэглэлээр зөвлөн эрх олгосон Т/22/11 тоот тогтоолыг ТУЗ-ийн хараат бус 2 гишүүн батласан/
  4. МВАРМ ХХК-ийн хувьцааны талаар хэлэлцэх /хойшлуулав/
7. 2022.03.31-ний өдөр 14 цагаас танхимаар хуралдсан ТУЗ хурлыг даргалсан. Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн батласан.
1. "Ариг банкны тогтворжуулах төлөвлөгөө"-ний талаар хэлэлцэх /Т/22/12 тоот тогтоол "Ариг банк" ХХК-ийн тогтворжуулах төлөвлөгөөг батлав/
  2. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ариунжаргалын чөлөөний хугацааг үргэлжлүүлэх хүсэлтийг хэлэлцэх /Т/22/13 тоот тогтоолоор 90 хоногийн чөлөө олгохоор шийдвэрлэв/
  3. Зарласан хувьцааг эргэлтэнд гаргах, хувьцаа эзэмшигчдэд санал болгох /Т/22/14 тоот тогтоолоор "Зарласан хувьцааны тоонд багтаан хувьцаа эргэлтэнд гаргах тухай" тогтоолыг батлан шийдвэрлэв. 21,166,565.90 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1182 ш хувьцааг эргэлтэнд гаргаж 682ш хувьцааг Улаанбаатар импэкс ХХК-д, 500 ширхэг хувьцааг Дэм санхүүгийн нэгдэл ХХК-д санал болгох мэдэгдлийг хүргүүлсэн/
  4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын товыг зарлах, хэлэлцэх асуудлыг батлах /асуудлыг хэлэлцүүлээгүй хойшлуулав/

Түүнчлэн "Ариг банк" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны даргаар, Эрсдэл удирдлагын хороо болон Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр ажиллаж Эрсдэл удирдлагын хорооны хурлаар "Банкийг тогтворжуулах төлөвлөгөө"-г хэлэлцэн ТУЗ-ийн хуралд оруулж шийдвэрлүүлсэн.

ТАЙЛАН БИЧСЭН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн

хараат бус гишүүн .....

П.Мөнх-Эрдэнэ

